

**Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх
ЗӨВЛӨМЖ**

Улаанбаатар хот

2018 оны 11 дүгээр сар 17

Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангид БШУ-ны сайдын 2014 оны А/240 тоот тушаалаар батлагдсан сургалтын хөтөлбөрийг мөрдөн хэрэгжүүлж байна. Цөм хөтөлбөр хэрэгжүүлэхэд багш нарт хамгийн бэрхшээлтэй зүйл нь бага ангийн хүүхдийн тоо их, сургуулийн ачаалал нэмэгдэж 3 ээлжээр хичээллэж байгаа явдал юм. Иймээс багш нар агуулгын дидактик нэгжийг томсгох, элементарчлах зэргээр тодорхой боловсруулалт хийж, сургуулийн хөтөлбөрөө өөрийн онцлогт тохируулан боловсруулах, цөм хөтөлбөрийг аль болох нээлттэй хэрэгжүүлэх, үр дүнтэй менежментийг нэвтрүүлэх нь зүйтэй байна. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах талаар сургуулиудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

- Сургууль бүр бага боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлаа тодруулан, түүнийхээ мөрөөр арга хэмжээ авч ажиллах
- Бага ангийн хичээлийн хуваарийг хүүхдийн бие бялдар, нас сэтгэцийн онцлогийг тооцон, шинжлэх ухааны үндэстэй зохиож, хэрэгжүүлэх
- Багшийн нэгж, ээлжит хичээлийн бэлтгэл хангах, сургалтын хэрэглэгдэхүүнийг хичээлийн болон суралцагчийн онцлогт нийцүүлэн ялгаатай байдлаар боловсруулан хэрэгжүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх сайн туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх
- Бага ангийн сургалтын менежерүүд багшийн өдөр тутмын үйл ажиллагаанд болон хичээл зохион байгуулахад хүүхэд бүрийн оролцоог хангах, хийж бүтээх, турших, хамтран суралцах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, явцын үнэлгээ хийх зэрэг хүүхэдтэй ажиллах нарийвчилсан арга зүйн зөвлөгөөг өгч байх, хамтран ажиллах, энэ чиглэлээр өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх
- Бага ангийн сурагчдын гэрийн даалгаврын агуулга, ачаалал, хэмжээг зохистой төлөвлөх, хэрэгжүүлэх, ялангуяа 1-р ангийн гэрийн даалгаварт хяналт тавьж, сурагчдын ачааллыг зөв тооцох
- Багш нар сурах бичиг, багшийн номыг цөм хөтөлбөртэй уялдуулан сайтар судалж, зориулалтын дагуу сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн болгон бүрэн ашиглах, албан ёсоор хэрэглэж буй сурах бичигт тусгасан дасгал, даалгавар, хийж бүтээх үйл ажиллагааг үр дүнтэй, бүрэн гүйцэд, бүтээлчээр ашиглах
- Сургалтын хөтөлбөрт нийцсэн эсэх нь тодорхойгүй нэмэлтээр ном, гарын авлагууд худалдан авч, хүүхэд эцэг эхэд ачаалал үүсгэхгүй байх
- Сургуулийн удирдлагууд бага боловсролын сургалтын хөтөлбөрөөр хүүхдэд эзэмшүүлэх чадварыг илрүүлэх даалгавар боловсруулах арга зүйгээр багш нарыг хангах, улмаар даалгаврын сан бүрдүүлэх анги дэвших болон улсын шалгалтад бэлтгэх талаар зохих байгууллагатай хамтран ажиллах